



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/159

Мандалговь

Зохиомол хээлтүүлгийн ажлыг
зохион байгуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Сайнцагаан сумын 2021 оны Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2.2.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Далай багийн нутаг дэвсгэрт Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлгийн ажлыг зохион байгуулсугай.

2. Зохиомол хээлтүүлгийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Дашням /ХААТасгийн мал зүйч/

Нарийн бичгийн дарга: Т.Батсайхан /ХААТасгийн ажилтан/


Гишүүд: Ж.Зоригтбаатар /Далай багийн Засаг дарга/

Б.Батбаяр / ХААТасгийн жолооч/

Уудам жаргалант ХХК

3. Дээрх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан Засаг даргад танилцуулж, батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Дашням)-д үүрэг болгосугай, шаардагдах 178,056 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг ЗДТГазрын дарга (Ц.Лхагвасүрэн), нягтлан бодогч (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ